

УДИРДАХҮЙН ЕРӨНХИЙ ОНОЛ

А.Гантуул- Хууль Сахиулахын Их сургууль.

*Хууль сахиулах удирдлагын академийн
Удирдахуйн уханны профессорын багийн дэд
профессор, цагдаагийн хошууч*

СУРАЛЦАХҮЙД СУРАЛЦАХ НЬ

Товч танилцуулга. Энэхүү өгүүллээр суралцах үйл, онол, арга зүйн зарим асуудлын талаар суралцагчдад мэдээлэл хүргэхийн зэрэгцээ идэвхтэй, мэдлэг бүтээж суралцахад дэмжлэг болох аргуудаас танилцуулахыг зорилоо.

Түлхүүр үг. Суралцах, сурах, сургалт, мэдлэг бүтээх, суралцахуйн онол, арга зүй, үр дүн.

Оршил

XXI зуун бол мэдлэг, мэдээллийн эрин зуун бөгөөд энэ ч утгаараа хамгийн үнэ цэнэтэй зүйл нь хувь хүний мэдлэг, ур чадвар болно. Өндөр мэдлэг, ур чадвартай хүн нийгмийн капитал байна гэх үзэл санаа дэлгэрч, мэдлэгийн менежмент, мэдлэгийн нийгэм гэх шинэ ойлголтын талаар эрдэмтэн судлаачид олон талаас нь асуудал дэвшүүлэн ярьж, бичиж байна.

Судлаач Д.Лхаашид “XXI зууны Монгол хүний хөгжил” өгүүлэлдээ “Хүний уураг тархинд 15-18 миллиард эд эс байх бөгөөд бид түүнийхээ дөнгөж 4-6 хувийг л ашиглаж байдаг. Үүнийг ашигт үйлийн илтгэлцүүрээр авч үзвэл маш доогуур үзүүлэлт юм. Энэ нь бид хүний мэдлэг, чадвараас асар их нөөц, боломжийг ашиглахгүй байна гэсэн үг юм” гэж тэмдэглэсэн бол хүний мэдрэлийн систем, уураг тархи, ухамсар, ой санамж, суралцах үйлийн биологийн үндсийг судалдаг шинжлэх ухаан болох тархи, мэдрэл судлал /neuroscience/-МН эрдэмтэн судлаачид хүн тархиныхаа боломжийн нэгээс ч бага хувийг ашиглаж байна гэжээ.

Иймд хууль сахиулах, аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий агентлаг, байгууллагын удирдах бүрэлдэхүүн болохоор бэлтгэгдэж буй суралцагч нартаа зориулан ухамсартай, идэвхтэй, мэдлэг бүтээж суралцах зарим онол, арга зүйн асуудлыг тайлбарлан энэхүү өгүүллээрээ хүргэж байна.

Суралцахуйн онолын тухай ерөнхий ойлголт


Суралцах үйл гэж чухам юу болох талаар нэвтэрхий толь, эрдэмтэн, судлаачдын бүтээлээс тодорхойлолт хайвал "Learning is the process of acquiring

knowledge, skills, values or developing the ability to perform new behaviors, attitude”¹ буюу “Суралцахуй бол мэдлэг, чадвар, дадал. соёлын үнэт зүйлсийг эзэмших, шинэ хандлагаар төлөвших үйл явц юм” гэжээ.

Мөн “Нийгэм, гүүхийн туршлагыг хойч үедээ дамжуулах үйл явц буюу тодорхой тогтолцоо бүхий мэдлэг, чадвар, дадал төлөвшүүлэх явц”^{1 2 3 3} гэж манай зарим эрдэмтэн, судлаачид тодорхойлсон байна.

“Урьдаас төлөвлөсөн, тодорхой зорилго, агуулга, түүнийг хэрэгжүүлэх арга. зохион байгуулалтын хэлбэр. хэрэглэгдэхүүн шаарддаг, тухайн нөхцөл байдал болон олон хүчин зүйлийн нөлөөнд байдаг үйл явц” гэж судлаач Н.Наранчимэг, Э.Төгөлдөр нар “Боловсролын удирдлага” бүтээлдээ, Г.Эрдэнэ-Очир “Хамгийн ерөнхий утгаар сурах, сургах үйл явцын нэгдэл” хэмээн “Ерөнхий дидактикийн үндэс” номондоо тус тус дурьджээ.

Сургалтыг онол, арга зүйн талаас нь олон жил судлан, бүтээл нь дэлхий нийтийн хүртээл болсон зарим эрдэмтдийн тодорхойлолтыг үзвэл “Суралцахуй нь учир шалтгаан нь бүрэн тайлагдаагүй “Хар хайрцаг” бөгөөд хайрцаг дотор чухам юу болдогийг суралцахуйн талаарх онол сургаалууд өөр өөрийнхөөрөө тайлбарладаг” гэжээ.



Дээр дурьдсанчлан эрдэмтэн, судлаачдын сургалт, суралцахуйн талаар маш олон тодорхойлолт байх хэдий ч хүний сурах үйлийг зөвхөн тодорхойлолтоор хязгаарлаж болохгүй, өргөн утга агуулгатай, олон талт ойлголт юм.

Шинжлэх ухааны үүднээс суралцахуйг тайлбарлаж. нийтээр хүлээн зөвшөөрсөн Зан үйлийн онол /Behaviorism theory/, Танин мэдэхүйн онол

¹ Encyclopedia Britannica

² Д.Ванчигсүрэн, Б.Энхтүвшин. Боловсрол судлалын ухагдахууны товч тайлбар толь., УБ 1994, 65 дахь тал

³ Dale H.Schunk. Learning theories: An educational Perspective., 7th edition. University of North Carolina at Greensboro.

/Cognitive theory/. Конструктив онол /Constructivist theory/. Нийгмийн хөгжлийн онол /Social development theory/, Ажиглан суралцах онол /Learning by observation theory/. Баруун, зүүн тархины онол /Right Brain vs Left Brain theory/, Оюуны ухааны олон талт онол /Multiple intelligence theory/, Оюун тархинд суурилсан сургалтын онол /Brain-based learning theory/ зэргийг дурьдаж болох бөгөөд эдгээр онолуудаас суралцах үйлд дэмжлэг үзүүлэхүйц гэж үзсэн зарим онолуудын гол үзэл санаатай танилцуулъя.

Зан үйлийн онол буюу Behaviorism theory: Энэ онолын гол үзэл санааг “Арга нь ямар байх нь төдийлөн чухал биш харин үр дүн чухал” гэж тайлбарлаж болох бөгөөд гол төлөөлөгчдөөр Оросын физиологич Иван Павлов. Америкийн сэтгэл зүйч Эдвард Торндайк /Edward L.Thorndike/. Жон Ватсон /John B.Watson/, Бурхас Скиннер /Burthus Frederic Skinner/ нарыг нэрлэж болно.

Олон удаагийн давтамжтай үйлдлийн үр дүнгээр суралцахуйн биологийн үндэс, хүрээлэн буй орчин суралцах үйлд асар их үр нөлөөтэй болохыг нотолсон энэ онол нь сурган хүмүүжүүлэх ухаанд олон талын ач холбогдолтойг эрдэмтэд нэгэнт хүлээн зөвшөөрсөн байдаг.

1900-аад оны эхээр Оросын физиологч Иван Павлов анх нохойн дээр туршилт хийж суралцахуйн онолын сонгодог нөхцөлт рефлекс /Classical condition-ийн хэлбэрийг нээжээ. Тэрээр нохойг хооллохын өмнө хонх дуугаргадаг байсан бөгөөд хэд хэдэн удаагийн хооллолтын дараа хонхны дууг сонсмогцоо нохойны ходоодны шүүс ялгарч байсан бөгөөд нөхцөлт рефлексийг дахин бусад амьтад дээр туршсаны дараа физиологчид суралцахуйн энэ хэлбэрийг хүний суралцах үйлд хэрхэн ашиглаж болохыг сонирхон судлах болсон байна.

Улмаар нөхцөлт рефлекийн хэлбэрийг цааш онолын түвшинд хүртэл баяжуулсан олон туршилтуудыг эрдэмтэд хийсэн байдаг. Тухайлбал: 1921 онд Америкийн сэтгэлзүйч Жон Ватсоны хийсэн айдас, гэнэтийн цочрол зэрэг сэтгэлийн хөдөлгөөнөөр дамжуулан шат дараатай олон удаагийн үйлдлээр хүнийг айдас, цочролоос нь салгаж болох, мөн сэтгэлзүйч Эдвард Торндайкийн гэрийн тэжээвэр амьтад дээр хийсэн туршилтын үр дүн, дүгнэлт зэрэг болно. Тэрээр “Аливаа үйлдэл таатай үр дагавартай байвал тухайн зан үйл илүү батжиж, түүнийг дахин хийхийг хүсдэг, эсрэгээр тааламжгүй үр дагавартай байвал тухайн үйлдлийн давтамж буурч түүнийг дахин хийхгүй байхыг хичээдэг. Тиймээс суралцахуй бол өдөөлт түүнд хариу үйлдэл үзүүлэх хооронд үүсч буй үр дүн болно”¹ гэжээ.

¹ Dale H.Schunk. Learning theories: An educational Perspective., 7th edition. University of North Carolina at Greensboro.

Америкийн сэтгэлзүйч Бурхас Скиннер 60 гаруй жилийн судалгааны ажлынхаа үр дүнд хүн шинэ зан үйл, зан үйлийн өөрчлөлтөд хэрхэн суралцдагыг тайлбарлаж, нөхцөлт үйл /operant conditionZ-ийн үндсэн зарчмуудыг тодорхойлсон. Энэ нь зан үйлийн дахин давтагдах байдал нь дэмжлэг, урамшуулалаар нэмэгдэж, зэмлэл шийтгэлээр багасах магадлалтай байдаг. Түүнчлэн суралцах үйлд хүний удамшил, төрөлхийн чанар, нийгмийн шинж зэрэг олон хүчин зүйл нөлөөлдөг гэж үзсэн.

Танин мэдэхүйн онол буюу Cognitive theory: Танин мэдэхүйн онол нь оюун ухаан буюу intelligence, оюуны үйл буюу mental behaviour, мэдлэг буюу knowledge, сэтгэхүй буюу thinking гэсэн ойлголтуудад гол анхаарлаа хандуулан суралцах үйлийг судалсан байдаг бөгөөд гол төлөөлөгчдөөр Швейцарын эрдэмтэн, сэтгэлзүйч Жиан Пиаже /Jean Piaget/, Америкийн эрдэмтэн, сэтгэлзүйч Бенжамин Блум /Benjamin Bloom/, Америкийн эрдэмтэн, боловсрол судлаач Роберт Гагне /Robert Gagne/ нарыг нэрлэж болно.

Швейцарын эрдэмтэн, сэтгэлзүйч Жиан Пиаже хүний танин мэдэхүйн үйлийн үндсийг судалж, өөрийн онолыг "Genetic Epistemology" гэж нэрлэсэн.

Харин Чикагогийн их сургуулийн профессор Бенжамин Блум боловсролын зорилго, үйл ажиллагааны чиглэлийг нарийвчлан тодорхойлж ангилал зүйн системийг бий болгожээ. Энэ нь боловсролын зорилгыг Cognitive domain буюу оюуны чадавхи, мэдлэг. Affective domain буюу мэдрэмж, хандлага, Psychomotor domain буюу бие бялдарын чадвар, дадал гэсэн гурван үндсэн шалгуураар хэмжих тухай ойлголт юм.

Түүний ангилал зүйн дээрх гурван шалгуурыг хамгийн энгийнээр тайлбарлавал суралцах үйл нь Skill-Knowledge-Attitude буюу Чадвар-мэдлэг-хандлага, Knowledge-Attitude-Skill буюу Мэдлэг-хандлага-чадвар, Do-Think-Feel буюу Үйл-сэтгэлгээ-мэдрэмж гэсэн гурван үйлийн нэгдэл байна.¹

Б.Блум танин мэдэхүй нь мэдлэг, ухаарал, хэрэглээ, анализ, синтез, үнэлгээ гэсэн зургаан түвшинтэй байна гэж тодорхойлсон байдаг бөгөөд тэрээр түвшин бүрт суралцахуйн зан үйлийг дараах байдлаар томьёолсон байдаг.

Мэдлэг /knowledgeZ-Эмхлэн зохион байгуулах, тодорхойлох. хуулбарлах, жагсаалт гаргах, тогтоох, сэргээн санах, нэрлэх, цэгцлэх, таних. нөхцөл байдлыг үнэлэх үйл явц.

¹ Dale H.Schunk. Learning theories: An educational Perspective., 7th edition, University of North Carolina at Greensboro.

Ухаарал ZcomprehensionZ-Ангилан ялгах, хэлэлцэх, илэрхийлэх, онцлогийг гаргаж тайлбарлах, ялган таних, өөрөөр илэрхийлэх, нягтлан шалгах, сонгох, хөрвүүлэх үйл явц.


Хэрэглээ ZapplicationZ-Хэрэглэх. сонгох, ашиглах, дүрслэн үзүүлэх, тайлбарлах, хувиарлах, шийдвэрлэх, бичих үйл явц.

Анализ ZanalysisZ-Задлан шинжлэх, дүгнэлт гаргах, тооцон бодох, тогтоох, харьцуулах. сөргүүлэн тавих, шүүмжлэх, ялгах. ялгаварлан үзэх, шалгаж үзэх, турших үйл явц.

Синтез /synthesis/- Гохируулж өөрчлөх, найруулах, зохион бүтээх. загвар гаргах. шинэ бүтээгдэхүүн гаргах, томъёолох. удирдах, төлөвлөх үйл явц.

Үнэлгээ ZevaluationZ-Дүгнэх, мэтгэлцэх. үнэлэх, харьцуулалт хийж сонгох, үнэлгээг зөвтгөх, таамаглах, сонгох, дэмжих, ач холбогдол өгөх үйл явц гэжээ.

2000-аад оны эхээр Лорин Андерсон, Дэвид Кратвол нарын эрдэмтэд Б.Блумын таксономийг өнөөгийн цаг үетэй нийцүүлэн дараах байдлаар засварлан сайжруулсан байдаг.



Б.Блумын боловсролын зорилгын ангилал зүйн агуулга, санааг 1956 оноос хойш дэлхийн бүхий л оронд сургах, суралцах үйлд ашиглаж байгаа бөгөөд Б.Блумын таксономиос хойш боловсролын зорилгын талаар олон янзын ангилал зүйн загварууд гарсан ч хамгийн үр нөлөөтэй нь энэ загвар байсаар байна.

Америкийн эрдэмтэн, боловсрол судлаач Роберт Гагнэ суралцах үйл нь нэр томъёог хэрэглэх, сайн мууг ялган таних, төсөөлөл бий болгох, зарчим дүрмийг хэрэглэх, асуудал дэвшүүлэх, шийдвэрлэх зэрэг хоорондоо уялдаа холбоотой, цогц үйл явц гэж үзсэн байдаг.

Конструктив онол буюу Constructivist Theory: Энэ онолын үзэл санаа Ж.Пиаже, Л.Выготский зэрэг олон эрдэмтдийн бүтээл санаан дээр тулгуурласан байдаг бөгөөд яг онол хэлбэртэй зангидсан хүнийг Брунер гэж үздэг.

Америкийн сэтгэлзүйч Брунер Жероме /Bruner Jerome/ суралцах үйл бол суралцагч өөрийн одоогийн болон урьдын сурч мэдсэн зүйл, ойлголт дээрээ тулгуурлан шинэ мэдлэгийг бий болгох идэвхтэй үйл гэж тодорхойлжээ.

Суралцагч мэдээллийг сонгож хувиргах, таамаглал дэвшүүлэх, шийдвэр гаргах зэргээр танин мэдэхүйн конструкци /загвар/-ийг бий болгож, утга санааг баттай ойлгох, туршлагадаа тулгуурлах, мэдээллийг боловсруулах чадвар юм.

Нийгмийн хөгжлийн онол буюу Social Development Theory: Оросын эрдэмтэн, сэтгэлзүйч Лев Выготский хэл шинжлэл, хэл ярианы хөгжлийн чиглэлээр ажиллаж байсан бөгөөд танин мэдэхүй, оюуны хөгжилд нийгмийн харилцаа, соёл голлох үүрэгтэй гэсэн таамаглалыг дэвшүүлсэн.

Түүний дэвшүүлсэн танин мэдэхүй, оюуны хөгжилд нийгмийн харилцаа, соёл голлох үүрэгтэй гэсэн үзэл санаа болон судлаач Н.Наранчимэг, Э.Төгөлдөр нарын “Сургалт-нийгмийн үйл явц болох нь”¹ загвар дээр тулгуурлан суралцахуй нь нийгмийн тодорхой үйл явц болно гэж судлаачийн зүгээс үзсэн тул суралцах үйлийг хүний төлөвшил, хөгжилтэй холбон авч үзлээ.

Энэ утгаараа суралцахуй нь хүнийг бие хүн болон төлөвших, хөгжихэд хэрэгцээтэй мэдлэг, чадвар эзэмшүүлэхэд чиглэсэн, системтэй зохион байгуулж буй үйл ажиллагаа бол хүний төлөвшил нь гадаад, дотоод хүчин зүйлийн нөлөөгөөр хүн эрүүл саруул өсөж, мэдлэг, боловсрол эзэмшин, хөдөлмөрч, ёс суртахуунтай, гоо зүйн мэдрэмжтэй, хүсэл зорилготой байж, аливаад өөрийн байр сууринаас хандах хэм хэмжээ болно.

Харин хүний хөгжил нь төрөлхийн болоод байгаль, нийгмийн хүчин зүйлийн нөлөөгөөр бие махбодь, оюунд гарсан чанарын өөрчлөлт юм.

Хүний хөгжин төлөвших үйл явц нь нийгэм дэх гадаад, дотоод хүчин зүйлийн шууд нөлөөнд байдаг тул тэдгээрийг ямар ч чиглэл, зорилгогүй орхиж болохгүй юм. Хүний хөгжил төлөвшил нь хүний төрөлхийн болон удамшлын шинж чанар, хүрээлэн буй орчин, хувь хүний хүсэл сонирхол, хичээл зүтгэл, нийгмийн зүгээс зориуд чиглүүлж, зохион байгуулж буй сургалт зэрэг олон объектив, субъектив хүчин зүйлээс шууд хамаарч байдаг. Иймд хувь хүнийг тодорхой зорилгод чиглүүлэхгүйгээр зөнд нь орхивол гадаад, дотоод орчны ямар нэг хүчтэй нөлөөнд автаж, хүнийг хааш нь ч хөтөлж болох талтай юм.

¹ Н.Наранчимэг, Э.Төгөлдөр. Боловсролын удирдлага., УБ 2014 он, 202 дахь тал

Хувь хүн хөгжиж төлөвшихөд тухайн хүний хүчин чармайлт субъектив нөлөөтэй байх бөгөөд хүн хичнээн таатай орчинд, хичнээн их мэдлэг, ур чадвартай эрдэмтэн, мэргэдээр хичээл заалгаад өөрөө сонирхож хүсэхгүй, хичээж зүтгэхгүй бол оюун ухаан, сэтгэл зүй, бие бялдарын хувьд төлөвшин хөгжих ямар ч боломжгүй юм.

Иймээс хүний хөгжил, төлөвшлийн асуудалд аль ч улс орон анхаарал хандуулж олон талаас нь судалж, сургалтын онол, арга зүйг боловсруулж иржээ.

Сүүлийн үед суралцах үйлийг хүн мэдээллийг байгаа чигээр нь хуулбарлан буулгах идэвхгүй субъект бус харин өмнө нь байсан өөрийн суурь мэдлэгтээ тулгуурлан хэрэгцээтэй мэдээллээр мэдлэгээ өргөжүүлэн баяжуулж, боловсруулалт хийх замаар шинэ мэдлэг бүтээх идэвхтэй субъект байх тухай ойлголт дэлгэрч суралцахуйн шинэ дүр төрх, төсөөллийг бий болгож байна.

Өөрөөр хэлбэл юмс үзэгдлийн талаарх олон салангид мэдлэг, мэдээллийг нэгтгэсэн, шууд хэрэглэхэд бэлэн байх "нөөц"-ийг мэдлэг, ур чадвар гэж ойлгож болох бөгөөд системчлэгдсэн бүтэц бүхий мэдлэгтэй хүн л аливаа асуудлыг шийдвэрлэхэд өөрийн нөөцийг бүтээлчээр ашиглаж чаддаг.

Иймд мэдлэг, ур чадвартай мэргэжилтэн болж бэлтгэгдэх нь академик түвшинд суралцаж буй эрхэм суралцагчдын туйлын зорилго байх учиртай.

Хүнийг хөгжүүлэн төлөвшүүлэх, боловсролын зорилго, агуулгыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн багш, суралцагчийн хамтын үйл ажиллагааны эрэмбэлэгдсэн үйлийн нэгдлийг сургалтын арга' хэмээн тодорхойлсныг удирдлага болгон суралцах явцдаа дараах асуудлуудад анхаарах шаардлагатай байна.

Суралцагч сургалтын явцад аливаа юмс үзэгдлийг бие даан судлах, олон эх сурвалжаас мэдээлэл авч боловсруулах, задлан шинжлэх, харьцуулан жиших, төсөөлөн бодох, нэгтгэн дүгнэх, өөрийгөө шударгаар үнэлэх, авьяас чадвараа нээн хөгжүүлэх, өөртөө өндөр шаардлага тавьж, алдаа дутагдлаа засч залруулах зэрэг үйлүүдийг нэн тэргүүнд хийж сурах нь идэвхтэй суралцах үндэс болно.

Ном бүтээл уншиж судлах, баримт материал цуглуулах, боловсруулах, дүгнэлт хийх зэргээр зарим мартсан мэдлэг, мэдээллээ сэргээн санах үйлээс суралцах явц эхлэнэ.

Түүнчлэн багшийн өгч буй мэдээллийг хүлээн авч, олон удаагийн ухамсартай үйлийн үр дүнд мэдлэг болгон авч үлдэх нь чухал.

Багшийн дэвшүүлэн тавьж буй асуудлыг шинжлэх ухааны болоод практик хэрэглээний түвшинд бие даан нягтлан судалж, хариу таамаглал дэвшүүлэх, түүнийгээ онолын үүднээс тайлбарлах, нотлох, ажиглах. туршилт хийх зэргээр бүтээлч хандлагыг өөртөө төлөвшүүлэх шаардлагатай.

Өөрийн сонирхол татсан сэдэв, агуулгын хүрээнд хэсэгчлэн тодорхой ухагдахууныг нарийвчлан судлах нь тухайн ойлголтын талаар гүн бат мэдлэгтэй болгодог.

Эцэст нь тэмдэглэхэд нэгэнт өөртөө зорилго тавиад байгууллага. хамт олондоо хүлээлт үүсгээд Академид суралцаж байгаа тохиолдолд “‘аргалаад өнгөрөх гэсэн сэтгэлгээ”-нээсээ нэн тэргүүнд салж. ёс суртахуун. мэдлэг, ур чадвар, хандлага, дадлага туршлагаараа салбартаа тэргүүлсэн манлайлагч болохын тул хичээн, идэвхтэй, мэдлэг бүтээж суралцах нь туйлын чухал юм.